



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/531

Арвайхээр сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүгд Найрамдах Узбекистан Улсын Дашкент хотод зохион байгуулагдах дэлхийн аварга шалгаруулах мас-рестлингийн тэмцээнд оролцох Хужирт сумын харьяат, тамирчин Б.Гарьдад 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх 1,000,000 (нэг сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 1061

D:My Doc. Zahiramj. Zasag darga